



## НИЙСЛЭЛИЙН АУДИТЫН ГАЗАР

14191 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
8 дугаар хороо, Лхагвасүрэнгийн гудамж,  
Нийслэлийн засаг захиргааны 5 дугаар байр,  
Утас: 32-77-34, Факс: (976-11) 32-01-54,  
E-mail: ub@audit.mn; http://www.city.audit.mn

2014.03.14 № 400  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ

Төсвийн тухай хуулийн 8.9.8, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.2 дахь заалтуудыг үндэслэн “Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар” нийслэлийн өмчит үйлдвэрийн газар /“НХОГ” НӨҮГ/ -ын 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан болон холбогдох бусад тайлан, илчлэл тодруулгад Нийслэлийн аудитын газрын санхүүгийн аудитын III албаны V баг аудит хийлээ.

### Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

“НХОГ” НӨҮГ-ын удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэл, Санхүүгийн тайлагналын Олон улсын стандартын дагуу бэлтгэх үүрэгтэй.

Санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэл, Санхүүгийн тайлагналын Олон улсын стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь аудитын байгууллагын үүрэг юм.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Нягтлан бодогчдын олон улсын холбооноос баталсан Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг биднээс шаарддаг. Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар “НХОГ” НӨҮГ-ын удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

1110400420

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

### **Зөрчилгүй санал дүгнэлт**

Бидний дүгнэлтээр “Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар” НӨҮГ-ын 2013 оны 1 дүгээр сарын 1-нээс эхэлж мөн оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон санхүүгийн тайлангийн санхүүгийн байдлын, санхүүгийн үр дүнгийн, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлтийн, мөнгөн гүйлгээний тайланг Санхүүгийн тайлагналын Олон улсын стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, зөв толилуулагдсан байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц. ОЧИРБАТ

